

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ МЭДЛЭГ, ЧАДВАР

ИТХ-ын төлөөлөгчдөд зориулав.



Улаанбаатар хот
2018 он



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

**Swiss Agency for Development
and Cooperation SDC**



*Empowered lives.
Resilient nations.*

Швейцарын Хөгжлийн Агентлаг, Монгол дахь НҮБ-ын Хөгжлийн
Хөтөлбөр, УИХ-ын Тамгын газар хамтран хэрэгжүүлж буй “Монгол
улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх нь” төсөл

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ МЭДЛЭГ, ЧАДВАР

ИТХ-ын төлөөлөгчдөд зориулсан сургалт

Хүрэх үр дүн: Иргэдийн оролцооны талаарх онол, арга зүйн мэдлэгээ дээшлүүлж, иргэдийн оролцоот үйл ажиллагааг зохион байгуулах арга барилаа сайжруулна.

Хичээл зохион байгуулах төлөвлөгөө

№	Агуулга	Сургалтын арга	Цагийн хуваарилалт	Сургалтын хэрэглэгдэхүүн
1	Иргэдийн оролцооны талаарх ойлголт	Дасгал 1. Оролцооны талаарх ойлголтоо нэгтгэх нь	25 минут	Дасгалын аргачлал, дэлгэц цаас, үзэг, наадаг жижиг өнгийн цаас
		Багшийн мэдээлэл	20 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
2	Иргэдийн оролцоог дэмжих арга	Багшийн мэдээлэл	25 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
		Дасгал 2. Бүлгийн ажил: Иргэдийн оролцооны хэлбэрүүдийг хэрэгжүүлэх нь	35 минут	Дасгалын аргачлал, жишээ, дэлгэц цаас, үзэг
3	Иргэдийн оролцоот үйл ажиллагааг зохион байгуулах нь	Багшийн мэдээлэл	25 минут	Лекцийн слайд, компьютер, проектор
		Дасгал 3. Бүлгийн ажил: Иргэдийн оролцоог идэвхжүүлэх боломж, арга зам	40 минут	Дасгалын аргачлал, жишээ, дэлгэц цаас, үзэг
4	Багшийн дүгнэлт		10 минут	
	Нийт		180 минут	



Дасгал 1. Оролцооны талаарх ойлголтоо нэгтгэх нь

Үргэлжлэх хугацаа: 25 минут

Аргачлал: Багш оролцогчдод *оролцоо* гэдгийг чухам юу гэж ойлгож байгаа талаараа үг эсвэл холбоо үгээр товч, тодорхой бичиж самбарт наахыг хүснэ. Оролцогч бүрт наадаг цаас тарааж өгсөн байх ба нэг цаасан дээр нэг санаа тэмдэглэхийг сануулна.

Бүх оролцогчид өөрсдийн санаа бодлоо илэрхийлсэний дараагаар багш оролцогчдын бичсэн санааг оюуны довтолгооны аргаар оролцооны хэрэгцээ; оролцооны тодорхойлолт/оролцоог тодорхойлох түлхүүр үг; оролцооны зарчим; оролцооны ач холбогдол; оролцоонд нөлөөлөх хүчин зүйл гэсэн хэсгүүдэд ангилан байршуулна.

Самбарт бичигдсэн санааг хичээлийн хүрээнд ярилцах онолын мэдээлэлтэй холбон тайлбарлаж, *эвлүүлгийн аргаар* оролцооны талаар нэгдсэн ойлголт, мэдлэг бүтээнэ. Шаардлагатай бол багш иргэдийн оролцоотой холбоотой орхигдсон зүйлийг нэмж тайлбарлан ташаа ойлголтыг залруулна.

Багшид өгөх зөвлөмж

Оролцогчдын санааг нэгтгэн дараах байдлаар нэмэлт мэдээлэл өгч, чиглүүлж болно.

Оролцоог хангах хэрэгцээ

- Асуудалд олон ургальч үзлээр хандах
- Бүх иргэдийн нэг ойлголт, нэгдмэл зорилготой болгох
- Бодитой, хүртээмжтэй мэдээллээр хангах
- Ялгаатай мэдлэг, чадвар, туршлага бүхий хүмүүсийг нэгтгэж, үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх гм.

Ач холбогдол

- Аливаа асуудлыг хамтран, оновчтойгоор шийдвэрлэх боломж бүрдэх
- Үйл ажиллагааг хамтын хүчин чармайлтаар, амжилттай хэрэгжүүлэх
- Хамтран ажилласнаар харилцан мэдлэг, туршлагаа солилцох
- Мэдээлэл, мэдлэгээ дээшлүүлж, чадваржих
- Иргэний эрхээ эдэлж, үүрэг, хариуцлагаа ухамсарлах
- Орон нутгийн хөгжилд өөрийн санаа бодол, үйл ажиллагаагаа нэмэрлэх гм.

Оролцоог хангахад шаардлагатай хүчин зүйл

- Мэдээллээр хангах
- Нэгдсэн зорилго, ойлголттой болгох
- Шийдэх асуудал, хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар бодитой мэдээлэл өгөх
- Үйл ажиллагаанд бүх талыг хамруулах
- Оролцогчдын мэдлэг, чадвар, туршлагыг судлах, үйл ажиллагаанд ашиглах гм

Оролцоог тодорхойлох түлхүүр үг

- Асуудал/үйл ажиллагаанд хамаарал бүхий иргэд
- Асуудал/үйл ажиллагааны талаарх мэдээлэл
- Иргэдийн мэдлэг, туршлага, чадвар
- Олон үзэл бодол
- Хамтын, оновчтой шийдвэр
- Иргэдийн эрх ба үүрэг, хариуцлага
- Хамтын ажиллагаа
- Харилцан зөвшилцол
- Тэгш оролцоот үйл ажиллагаа
- Чадваржих, хөгжих боломж
- Үнэлгээ, дүгнэлт
- Орон нутгийн хөгжилд оруулах хувь нэмэр зэрэг түлхүүр үгээр тодорхойлж болно.

1.1. Иргэдийн оролцооны талаарх ойлголт

Иргэдийн оролцоо ба сайн засаглал

Оролцооны талаар 1960-аад онд барууны улс орнуудад анхлан яригдаж эхэлсэн бол 1980-аад оноос *хөгжилд оролцуулах-participation in development; оролцоонд тулгуурласан хөгжил-participatory development* гэсэн хоёр хандлага түгэн дэлгэрч, нийгэм, улс төрийн амьдралд иргэдийн оролцоо нэн чухал болохыг хүлээн зөвшөөрсөн. Хүмүүнлэг-ардчилсан нийгэм, иргэн төвтэй төрийн удирдлагын гол шалгуур болох *сайн засаглалыг* ил тод, хариуцлагатай, оролцоотой, үр ашигтай засаглалыг хэмээн ойлгож, түүний үндсэн шинжийг дараах байдлаар тодорхойлж байна (Зураг 1). Сайн

засаглалын үндсэн шинж нь иргэдийн оролцоог хангах; хууль дээдлэх ёсонд тулгуурлан шийдвэр гаргах; Засгийн газрын үйл ажиллагаа ил тод явагдах; иргэдийн хэрэгцээ, сонирхлыг мэдрэх; бүх хүнд тэгш хандах; төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай, үр нөлөөтэй зарцуулах; улс төрийн хариуцлагатай байх; хөгжлийн төлөвлөлтөд алсын хараатай хандах явдлыг хамруулна (Деннис Рондинэли, 2008).

Өөрөөр хэлбэл бодлого, үйл ажиллагаанд оролцох боломжийг хангасан, оролцдог, оролцсноор эерэг үр дүн ажиглагддаг байх нь сайн засаглалын үндсэн шинж болж байна.

Зураг 1. Сайн засаглалын үндсэн шинж



Аливаа улс оронд ардчилал, сайн засаглалын бэхжүүлэхэд нутгийн өөрөө удирдах байгууллага болох аймаг, сум, дүүргийн *иргэдийн төлөөлөгчдийн хурал*; баг, хорооны *иргэдийн нийтийн хурал* чухал үүрэг гүйцэтгэнэ. “Нутаг дэвсгэрийн нэгжүүд өөрийн хариуцлагын хүрээнд тухайн нутаг *дэвсгэртээ* хамаарах асуудлыг оршин суугчид, иргэдийнхээ сайн сайхны төлөө зохицуулан хянах эрх, үүргийн чадамжийг нутгийн өөрийн удирдлага гэнэ.” (Торонтогийн тунхаглал, 2-р зүйл) гэсэн тодорхойлолтыг эш үндэс болговол нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд иргэдийн оролцоог хангах; нээлттэй, ил тод байдлыг бий болгох; хариуцлага, үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх хэрэгцээ, шаардлага тавигдаж байна. Цаашилбал, “нийт иргэд нутгийн өөрийн удирдлага, орон нутгийн хөгжил дэвшилтэй холбоотой мэдээлэл авах, шийдвэр гаргахад оролцох эрхтэй” (Рио де Жанейрогийн тунхаглал, 1-р зүйл) гэснээс нутгийн өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх нь сайн засаглалын үндсэн шинж болох иргэдийн оролцоотой салшгүй холбоотой болох нь харагдаж байна.

Иргэдийн оролцооны онцлог, ач холбогдол

Энгийнээр тодорхойлбол, төрийн бодлого шийдвэр, үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн тулд иргэдийн зүгээс хийж байгаа аливаа үйлдлийг *иргэдийн оролцоо* гэж ойлгож болох юм. Өөрөөр хэлбэл, иргэдийн оролцоо нь бодлого, хөтөлбөрийг амжилттай томъёолох, тодорхой үйл ажиллагааг үр дүнтэй *хэрэгжүүлэх* урьдач төдийгүй явцын нөхцөл нь болдог. Энэ нь иргэдийн оролцоог дараах хүрээнд тодорхойлон ойлгодогтой ч уялдаж байна (A.W.Lofquest, 1993).

Иргэд бол:	Объект (Аливаа бодлого шийдвэр, үйл ажиллагаа иргэдэд чиглэдэг).
	Хүлээн авагч (Бодлого шийдвэр, үйл ажиллагааны дүнд иргэдэд өөрчлөлт гардаг).
	Нөөц (Бодлогын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ зэрэг бүхий л үйл явцад оролцоно).
	Түншлэгч тал (Хувийн хэвшил, ОУ-ын байгууллага, ТББ зэрэг оролцогчдын нэгэн адил төртэй хамтран ажиллах боломжтой).

Ийнхүү иргэд, төрийн бодлого шийдвэр, нийгэмд гарч буй өөрчлөлтөд идэвхгүй *ажиглагчийн* байр сууринаас ханддаггүй, харин ч түүнд хариу өгдөг, тодорхой үйлдэл үзүүлдэг тул нийгмийн бүтэц, иргэд хоорондоо нягт холбоотой (A.Giddens, 1979). Иргэд оролцооны эрхээ эдлэхгүй, өөрөөр хэлбэл өөрт хамаатай асуудлаар санал бодлоо илэрхийлж, шийдвэр, үйл ажиллагаанд оролцож чадахгүй бол ардчилсан зарчим алдагдаж, дарангуйлал, шударга бус байдал тогтох эрсдэл бий. Иргэдийг оролцуулснаар тэд шинэ мэдээлэл авах, мэдлэг, туршлагаа сайжруулах, улмаар чадавхижин хөгжих боломжийг бүрдүүлнэ.

Харин төрийн хувьд тодорхой зорилгод хүрэх үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг татан оруулах нь *идэвхтэй*, хөгжил хөдөлгөөнтэй оролцоог бий болгодог (P.Oakley, 1991) бөгөөд дараах ач холбогдолтой. Үүнд:

- Мэдээллийн олон эх сурвалж, асуудлын шийдлийн олон хувилбараас оновчтойг нь сонгох боломж бүрдэх
- Төр, иргэдийн хоорондын уялдаа, холбоог сайжруулж, харилцааг нээлттэй болгох
- Хариуцлага, тунгалаг байдлыг сайжруулах
- Төлөөллийн зарчим, олон нийтийн итгэлийг бэхжүүлэх зэрэг болно.

Иргэдийн оролцооны зарчим ба бүтээлч оролцоо

Иргэдийн иргэдийн оролцоо нь дараах *зарчмын* үндсэн дээр хэрэгждэг байна (International Development Research Center, 2005). Үүнд:

- Асуудал, үйл ажиллагааны талаар бодитой мэдээллээр хангаж, иргэдийн ойлголтыг нэгтгэх
- Асуудал, үйл ажиллагаанд олон ургалч үзлээр хандаж, зөвшилцөлд хүрэх
- Мэдлэг, чадвар, туршлагадаа тулгуурлан оновчтой шийдвэр гаргах
- Үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хамтран оролцож, зорилгодоо хүрэх боломжийг дээшлүүлэх
- Хамтран ажиллаж, харилцан суралцаж, чадавхижих
- Үнэлгээ, эргэх холбоог хөгжүүлснээр үр дүн, тогтвортой байдлыг бий болгох зэрэг болно.

Өөрөөр хэлбэл, аливаа үйл ажиллагаанд дээрх шалгуурууд бүхэлдээ хангагдаж байвал энэ нь оролцоог хангасан үйл ажиллагаа болно. Дээрх зарчмууд өөр хоорондоо харилцан уялдаатай, нэг зарчмыг амжилттай хэрэгжүүлэх нь нөгөө зарчмын хэрэгжилтэд нөлөөлдөг онцлогтой. Жишээ нь: Тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх хамгийн оновчтой арга замыг тодорхойлохдоо оролцогчдын санаа бодол, мэдлэг, туршлага, чадварыг харгалзан үзсэнээр тухайн үйл ажиллагаа амжилттай хэрэгжүүлж, зорилгодоо хүрэх боломжийг дээшлүүлнэ. Мөн үйл ажиллагаандаа байнгын үнэлгээ, дүгнэлт өгч, эргэх холбоог хөгжүүлэн ажиллавал оролцоот үйл ажиллагааны үр дүн, үр нөлөө дээшилнэ.

Оролцооны зарчимтай холбоотойгоор *бүтээлч оролцоо* гэсэн ойлголтыг тодруулах шаардлага бий. Энэ нь дараах шинжийг агуулсан оролцоо юм (Ж.Чанцалдулам, С.Оюунтуяа, 2011).

Итгэлцэл	Нотолгоонд суурилсан	Үр дүн, шийдэлд чиглэсэн	Тогтвортой
•Төр-иргэдийн хооронд итгэлцэл бий болсон	•Асуудал, үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээллийг түгээсэн	•Тодорхой үр дүн гарч, иргэдэд мэдрэгдсэн	•Нэг удаагийн, зохион байгуулалтай бус сайн дурын, тогтвортой оролцоо бий болсон

1.2. Иргэдийн оролцоог дэмжих арга

Иргэдийн оролцооны үе шат

Оролцоо хэмээх ойлголтыг үг зүйн талаас авч үзвэл оролцох үйлийн нэр бөгөөд туслалцаа, хамжилцаа; хамааралцах, хамтрах гэсэн утгатай, аливаа асуудлыг шийдвэрлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг дэмжин ажиллах, хамжилцан гүйцэтгэх, уг үйлд бие, сэтгэлээрээ байлцах, хамтран бүтээх гэсэн агуулгатай ойлголт юм. Гэхдээ хамтран ажиллах боломж шууд бий болдоггүй, тодорхой хугацаа шаардахын зэрэгцээ

тухайн бодлого шийдвэр, үйл ажиллагааны талаар мэдээлэл авахаас эхлээд нэлээд хэдэн үе шатыг дамждаг байна (S.B.Ribkin, 1996). Үүнд:


1. Мэдээлэлгүй байх
2. Мэдээлэл авах
3. Сонирхол төрөх
4. Мэдээлэх
5. Зөвлөлдөх
6. Туршиж үзэх
7. Даган дуурайх
8. Хэрэгжүүлэх.

Иргэдийн оролцоог жинхэнэ утгаар хэрэгжүүлэхийн тулд оролцоог хангах урьдач нөхцлийг бүрдүүлэх буюу үйл ажиллагааны талаар ойлголт, мэдээлэл өгөх, тэдний мэдлэг, чадвар, туршлагыг тандах, үйл ажиллагаанд оролцох боломжийг судлах нь чухал юм. Ингэснээр тухайн үйл ажиллагаанд оролцох сонирхол төрөх, энэ талаараа бусдад мэдээлэн зөвлөлдөх, улмаар туршиж үзэн хэрэгжүүлэх зэргээр хувь хүний мэдлэг, хандлага, зан үйлд өөрчлөлт гарна.

Үүнтэй уялдуулан иргэдийн оролцоог цаг хугацаа, оролцогчдын хүсэл сонирхол, асуудал шийдэх байдлаар нь шатлан авч үзэх хандлага байдаг. Жишээ болгон Рожер Харт, Шерри Арнштейн, Клейр Ларднер, Пилл Треседер нарын боловсруулсан оролцооны шатлалын талаарх онол, загварыг дурдаж болно.

Судлаач Шерри Арнштейн АНУ-ын төрийн үйл ажиллагааны төлөвлөлтөд иргэд хэрхэн оролцож байгааг тодорхойлох зорилгоор “Оролцооны шатлал”-ын загвараа 1969 онд боловсруулсан. Энэ нь иргэдийн оролцооны түвшинг тодорхойлсон хамгийн анхны загварт тооцогддог. Загварт оролцоог 8 үндсэн үе шат, 3 үндсэн түвшинд ангилан авч үзсэн байна.

Зураг 2. Оролцооны үе шат



Иргэдийн бодит буюу бүтээлч оролцоо нь идэвхтэй, тогтмол, чанартай, сайн дурын оролцоо юм. Бодит оролцоо нь богино хугацаанд бий болдоггүй, үүнийг бий болгоход харьцангуй урт хугацаа, мэдлэг, арга барил, эв дүй шаардагддаг.

Оролцооны шатлал хэмээх ойлголт нь оролцоог агуулга, хөгжил төлөвшлийн талаас нь авч үздэг. *Өөрөөр* хэлбэл, хэлбэрийн хувьд хүмүүс ямар нэгэн үйл ажиллагаанд оролцож байгаа мэт боловч энэ нь угтаа бол оролцоо биш байх хандлага ажиглагдаж болно. Гэхдээ тодорхой хугацааны дараа оролцооны үйл явц төлөвшиж, оролцогч талууд чадваржиж оролцоо жинхэнэ утгаараа, тогтвортой үргэлжлэх боломж бүрддэг.


Иргэдийн оролцооны арга хэлбэр, тэдгээрийн зохицуулалт

Иргэдийн оролцооны арга хэлбэр нь иргэдийн оролцооны шатлалтай холбоотойгоор тодорхойлогддог. Аливаа үйл ажиллагаанд иргэд, олон нийтийг оролцуулах үндсэн дөрвөн арга байдаг. Эдгээр нь:

1. Мэдээлэх оролцоо: Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтнаас иргэдэд зориулан төрийн бодлого, үйл ажиллагааны талаар үнэн бодитой, шинэ тутам мэдээллийг түргэн шуурхай, ойлгомжтой, эмх цэгцтэй байдлаар түгээх үйл ажиллагааг багтаана.
2. Зөвлөлдөх оролцоо: Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, албан тушаалтнууд аливаа бодлого, шийдвэр гаргах, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ иргэдтэй чөлөөтэй санал солилцож, тэдний санаа бодлыг тусгах үйл ажиллагаа орно.
3. Шууд/идэвхтэй оролцоо: Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын түвшинд бодлого, шийдвэр гаргах, үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд иргэд шууд, идэвхтэй оролцохыг хэлнэ.
4. Хянах оролцоо: Иргэдийн оролцооны хөгжсөн хэлбэр бөгөөд төрийн бодлого, үйл ажиллагаанд тавих иргэдийн үр дүнтэй хяналтыг багтаана.

Мэдээлэх, зөвлөлдөх, идэвхтэй оролцох хэлбэрүүд нь өөр хоорондоо харилцан холбоотой бөгөөд тус бүртээ өөрийн гэсэн онцлогтой байдаг. Зураг 3-т үзүүлсэнчлэн мэдээлэх оролцоо нь *нэг урсгалтай харилцаа*; зөвлөлдөх оролцоо нь *хоёр урсгалтай харилцаа* бол идэвхтэй оролцох нь *итгэл, түншлэлд суурилсан харилцаа* болно.

Зураг 3. Иргэдийн оролцоо ба нөлөөллийн түвшин



Иргэд ИТХ-ын талаар мэдээлэлтэй болох, тухайн мэдээлэлд тулгуурлан бодлого, үйл ажиллагааны талаар санал бодлоо илэрхийлэх, цаашлаад байгууллагын үйл ажиллагаанд оролцох нь олон нийтийн оролцооны идэвхтэй түвшин, үр дүнтэй нөлөөллийг тодорхойлдог байна.

Зарим эх сурвалжид иргэдийн оролцооны дөрөв дэх хэлбэр болох хяналтыг иргэдийн шууд/идэвхтэй оролцоонд хамааруулж үзэх нь бий.

Улс орнууд иргэдийн оролцооны эрхийг хууль тогтоомж, дүрэм журмаараа баталгаажуулах шаардлагатай. Иргэд, олон нийтийн оролцоог Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 105 хуулиар зохицуулж байгаа бөгөөд эдгээр хуульд оролцооны хэлбэр бүрт хамаарах дараах зохицуулалтыг тусгасан байна (С.Ганцэцэг, 2017). Үүнд:

Мэдээлэх хэлбэрийн оролцоог зохицуулсан нийт 68 хууль байгаа ба эдгээр нь төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд, нийтийн эрх зүйн хуулийн этгээдийн ил тод байдлыг хангах; хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх; мэдээлэл авах хүсэлтийг шуурхай шийдвэрлэх; шийдвэрлээгүй нөхцөлд гомдол гаргах; сургалт сурталчилгаа таниулга хийх зэрэг арга механизмаар мэдээлэх оролцоог хэрэгжүүлэхээр зохицуулсан байна.

Иргэдтэй зөвлөлдөх оролцоог хангах үйл ажиллагаа нь сонгуульд оролцох; санал асуулга явуулах; бодлого, хууль тогтоомжид болон шийдвэр гаргахын өмнө иргэдээс санал авч, тусгах; иргэдээс өргөдөл гаргах; олон талт бүтцийн нэгж /хороо, зөвлөл ажиллуулах зэрэг зохицуулалтаар илэрнэ. Энэ хэлбэрийн оролцоог нийт 25 хуулиар зохицуулж байгаа болно.

Иргэний идэвхтэй оролцоог хангах хэлбэр нь нийтийн сонсгол; цуглаан; мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг; ИНБ, ТББ-уудтай хамтран ажиллах; тэдгээрээр тодорхой ажил, үүрэг гүйцэтгүүлэх; олон талт бүтцийн нэгжид төлөөллөө оролцуулах (үнэлгээний хороо, стандартчиллын хороо) зэргээр хэрэгжиж байгаа ба шууд оролцоог нийт 44 хуульд тусгаж өгчээ.

Иргэд, олон нийтээс хяналт үнэлгээ хийх хэлбэр нь хуулийн хэрэгжилтэд хамтран болон дангаар хяналт тавих; хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх; зөрчил гарсан нөхцөлд өргөдөл гомдол гаргах; нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх зэрэг зохицуулалтаар 24 хуульд тусгагдан хэрэгжиж байна.



Дасгал 2. Бүлгийн ажил: Иргэдийн оролцооны хэлбэрүүдийг хэрэгжүүлэх нь

Үргэлжлэх хугацаа: 30 минут

Аргачлал: Багш оролцогчдыг ойролцоо тооны гишүүнтэй 4 бүлэгт хуваах ба бүлэг бүр дараах даалгаврыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Иргэдийн оролцоог хангах үйл ажиллагаанд мэдээлэх, зөвлөлдөх, шууд болон хянах оролцооны ямар арга хэлбэрийг (нээлттэй хэлэлцүүлэг, санал асуулга, нийтийн сонсгол, уулзалт гэх мэт) ашигладгийг жагсаан бичнэ.
2. Тэдгээр арга хэлбэрээс хамгийн үр дүнтэй гэж үзэж буй 1-2 арга хэлбэрийг сонгож, үндэслэлийг тайлбарлана.

Бүлгийн ажлын үр дүнг нэг гишүүн танилцуулах ба танилцуулгын хүрээнд асуулт тавьж, харилцан ярилцах, санал, туршлага солилцох боломжтой байна.



Багшид өгөх зөвлөмж

Багш бүлгүүдээс гарсан саналд тулгуурлан мэдээлэх, зөвлөлдөх, шууд оролцох болон хяналт тавих ямар арга хэрэгслүүд ашиглах боломжтойг танилцуулж, ашиглах боломжтой зарим аргыг нэмж санал болгоно. Бүлгүүдээс хамгийн үр дүнтэй хэмээн сонгож буй арга хэлбэрүүдийн онцлог, давуу болон сул талыг тайлбарлана.

1.3. Иргэдийн оролцоот үйл ажиллагааг зохион байгуулах нь

Иргэд, олон нийтийн оролцоог хангах үйл ажиллагааны стандарт

Иргэдийн оролцоог хангасан аливаа үйл ажиллагааг амжилттай зохион байгуулахын тулд иргэдийн оролцооны зарчим, стандартуудыг мөрдөх шаардлага тавигддаг. Иймээс иргэдийн оролцооны стандарт, дүрэм журмуудыг батлан хэрэгжүүлж байна. Тухайлбал: АНУ-ын Олон нийтийн оролцооны нийгэмлэгээс олон

нийтийн оролцооны стандартыг боловсруулан гаргаж, энэхүү баримт бичигт иргэдийн оролцоог хангах дараах шаардлагыг тусгаж оруулсан байна. Үүнд:

- Амьдрал, үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гарахад олон нийтийн дуу хоолойг сонссон байх;
- Оролцогчдыг бүтээлч, зохистой арга замаар оролцоход шаардагдах мэдээллээр хангах;
- Асуудлыг тодорхойлоход зөвшилцөл, ойлголцол, хамтын идэвхитэй үйл ажиллагаанд үндэслэх;
- Үйл явц нь янз бүрийн сонирхлуудыг холбож, оролцогчийн санал санаачилгыг дэмжиж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн байх;
- Шийдвэр, үйл ажиллагаанд хамааралтай оролцогчдыг үйл явцад татан оролцуулж, тэдний санал санаачилгыг шийдвэрт харгалзах;
- Оролцогч талыг оролцооны чиглэл, зохион тодорхойлоход оролцогчдыг татан оролцуулах;
- Оролцоо шийдвэрт хэрхэн нөлөөлсөнийг оролцогчдод тухай бүр тодорхой мэдээлэх зэрэг болно.

Иргэдэд мэдээлэл түгээх үйл ажиллагаа

Юуны өмнө мэдээлэл түгээх гэдэг нь тодорхой агуулга, үзэл санааг мэдээллийн орон зайд буюу *иргэд, олон нийтэд нийлүүлэх үйл явц* (Б. Болд-Эрдэнэ, Г. Өнөрбаяр, 2011) болохыг тэмдэглэх шаардлагатай. Мэдээлэл түгээх үйл явц нь нэгдүгээрт, *иргэдийн хүссэн мэдээллийг тэдэнд гарган өгөх*, хоёрдугаарт, *иргэдийн хүсэлтээр бус, тодорхой зорилгоор тэдэнд хамаатай мэдээллийг хүргэх* гэсэн хоёр өөр чиглэлээр хийгддэг ба үүнтэй холбоотойгоор мэдээлэл түгээх идэвхгүй ба идэвхтэй гэсэн хоёр үндсэн аргыг тодорхойлж болно (OECD, 2001).

Мэдээлэл түгээх идэвхгүй арга: Иргэд эрхийнхээ хүрээнд мэдээлэл авахыг хүсэж, холбогдох ИТХ-д хүсэлт гаргасны үндсэн дээр мэдээллээр хангагдах арга юм. Уг аргын тухайд мэдээллийн цар хүрээ тэдэнд шаардлагатай тодорхой мэдээлэл, лавлагаагаар хязгаарлагддаг, иргэд ямар мэдээлэл авах талаараа тодорхой хүлээлтийг бий болгож, хэрэв хүссэн мэдээллээ авч чадвал сэтгэл ханамжтай үлддэг, тухайн мэдээллийг гол төлөв хувийн зорилгоор ашигладаг гэх мэт онцлогтой.

Мэдээлэл түгээх идэвхтэй арга: ИТХ-ын санаачилгаар бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаарх мэдээллийг иргэд, олон нийтэд түгээх аргыг идэвхтэй арга гэнэ. Улс орнуудын туршлагаас харахад, иргэдэд дараах зорилгын улмаас идэвхтэй аргаар мэдээлэл түгээдэг байна. Үүнд:

- Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааныхаа талаар танилцуулах
- Үйл ажиллагаандаа зориулан дэмжлэг, санхүүжилт цуглуулах
- Олон нийтийн анхаарлыг татах, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах
- Бодлого, хууль тогтоомжид зөрөг нөлөө үзүүлэх

- Иргэд, олон нийтийн хандлагыг өөрчлөх зэрэг болно.

Үүнээс иргэд, олон нийтийн оролцоо, дэмжлэгийг авахын тулд мэдээлэл түгээх идэвхтэй арга хэлбэрийг ашиглах шаардлагатай болох нь харагдаж байна. Ингэхдээ:

- Бодлого, шийдвэр, үйл ажиллагааны талаар биечилсэн болон видео танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах
- Сонин, сэтгүүл, зурагт хуудас, товхимол, гарын авлага зэрэг хэвлэмэл материал боловсруулж, тараах
- Мэдээллийг өрх, иргэн бүрт биечлэн хүргэх, цахим болон цаасан захидал бичих
- Мэдээллийн төв, мэдээллийн болон зарлалын самбар, мэдээлэл өгөх утас ажиллуулах
- Бага хурал, үзэсгэлэн болон хэвлэлийн бага хурал зохион байгуулах зэрэг болно.

Сүүлийн жилүүдэд мэдээлэл, харилцаа холбооны технологи өндөр хөгжиж байгаатай холбоотойгоор хэвлэл, бичлэг, кино, радио, телевизээс гадна интернет, гар утсыг олон нийтийн хэвлэл мэдээллийн үндсэн хэрэгслүүдэд хамруулж, эдгээрийг “seven mass media” гэж нэрлэж байна. Үүнтэй холбоотойгоор цахим хуудас, цахим мэдээллийн төв, олон нийтэд зориулсан нээлттэй хуудас (facebook, twitter гэх мэт), гар утас зэрэг нь мэдээлэх оролцоонд түлхүү ашиглагдаж байна.

Монголын нөхцөлд ИТХ-ын үйл ажиллагаанд мэдээлэл, харилцаа холбооны технологи бүрэн нэвтрээгүй, бүх орон нутагт мэдээллийг хэвлэл мэдээллийн үндсэн 7 хэрэгслээр тархаах боломжгүй байгаа тохиолдолд *биечилсэн уулзалт хийж, аман зар тугээх* аргыг ашиглах шаардлага тавигдаж байна. Мөн тодорхой нэг мэдээллийг иргэдэд түгээхдээ олон нийтийн хэвлэл, мэдээллийн зөвхөн нэг арга хэрэгслийг ашиглах нь тохиромжгүй, боломжит аргуудыг хослуулан хэрэглэх нь үр дүнтэй.

Иргэдтэй зөвлөлдөх үйл ажиллагаа

Иргэдтэй зөвлөлдөх үйл ажиллагааны хүрээнд иргэний зөвлөл, иргэний танхим, нээлттэй хэлэлцүүлэг, бүс нутгийн эсвэл тодорхой асуудалд чиглэсэн форум, санал асуулга, фокус бүлгийн ярилцлага, иргэдийг сонсох өдөрлөг, иргэдийн санал, зөвлөмж авах хайрцаг ажиллуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Эдгээрээс хамгийн түгээмэл хэрэглэгддэг арга нь нээлттэй хэлэлцүүлэг юм. Нээлттэй хэлэлцүүлэг нь аливаа асуудлыг тодорхойлоход нийт өрх, иргэдийн төлөөлөл, нийгмийн бүлгүүдийг бүрэн хамруулж, тэдний санаа, бодлыг сонссоны үндсэн дээр эрх ашигт нь нөлөөлөхүйц үйл ажиллагаа хэрэгжүүлэх, шийдвэр гаргах тохиолдолд түгээмэл ашиглагдана.

Нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах үед зар түгээх тогтолцоо, иргэдийн тэнцүү төлөөлөл, баримтлах дүрэм журам, хэлэлцүүлгийн идэвхижүүлэгчдийн чадвар чухал байдаг. Нээлттэй хэлэлцүүлгийг үр дүнтэй хөтлөн явуулахдаа эхлэхээс дуусах

хүртэлх үйл ажиллагааг хэлэлцүүлгийн бэлтгэл, хэлэлцүүлгийн үйл явц, хэлэлцүүлгийн дараа гэсэн гурван үе шатанд хувааж, үе шат бүрт төлөвлөгөө гаргаж ажиллах хэрэгцээг бий болгодог.

Хэлэлцүүлгийн бэлтгэл үе шатанд дараах зүйлүүдийг эн тэргүүнд анхаарна. Үүнд:

- Хэлэлцүүлгийн зар мэдээ түгээх: Зар мэдээ нь хэлбэрийн хувьд боломжит бүхий л хэлбэрийг ашиглах хэрэгтэй бөгөөд агуулгын хувьд хэлэлцүүлэг болох газар, огноо, цаг, хэлэлцэх асуудал, нэмэлт мэдээллүүдийг агуулсан байх шаардлагатай. Мөн хэлэлцүүлэгт ирж амжихгүй иргэдэд саналаа өгөх сувгууд нь тодорхой байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарна.
- Хэлэлцүүлгийн хөтөлбөр боловсруулах: Хэлэлцүүлгийн хүрээнд ямар үйл ажиллагаа хийгдэх, тэдгээрийг хэн хариуцаж, ямар байдлаар явуулах, түүнд хэдий хэмжээний хугацаа орох, хөтөлбөрийн хэрэгжүүлэхэд ямар техник, хэрэгсэл шаардагдах зэргийг урьдчилан тооцоолж бэлтгэнэ. Түүнчлэн хэлэлцүүлгийн хөтөлбөр боловсруулахаас өмнө хугацааны хувьд 7 хоногийн ямар гарагийг сонгох, хүмүүсийн идэвхитэй оролцоог хангахын тулд хэлэлцүүлгийн үргэлжлэх хугацаа болон эхлэх цагийг тооцож сонгох асуудалд анхаарах хандуулах шаардлага бий. Хөтөлбөр боловсруулахад өмнө хийгдсэн хөтөлбөрийн сургамж, туршлага ихээхэн чухал байдаг.
- Зохион байгуулалтын бэлтгэл: Хэлэлцүүлэг хийх газрыг сонгож (ойрхон, хүмүүс мэддэг газар сонгох нь чухал), сайтар бэлтгэх нь чухал. Хэлэлцүүлгийн зохион байгуулагчид тухайлбал идэвхжүүлэгч төвийг сахисан, иргэдийн тэгш оролцоог хангахыг эрмэлзсэн байх хэрэгтэй. Мөн ширээ, сандлын байрлал, өрөөний зохион байгуулалт, техник хэрэгсэл гэх мэт жижиг гэлтгүй төлөвлөлт хийх нь хэлэлцүүлгийн амжилтын үндэс болдог.

Хэлэлцүүлгийн үйл явц: Хэлэлцүүлгийн үед оролцогчдын бүртгэл хийж, хэлэлцүүлгийн дэг/хөтөлбөрийн дагуу хөтлөн явуулахад зохион байгуулалт, эмх цэгц чухал гэдгийг анхаарах хэрэгтэй. Хэлэлцүүлгийн явцад иргэдийн санаа бодлыг сонсох, харилцан зөвшилцлийн уур амьсгал бүрдүүлэх, тэгш оролцоог хангах, нөхцөл байдлын талаар зөв ойлголт өгөх, хэлэлцүүлгийн уур амьсгалыг мэдэрч, сэдвээс хазайсан нөхцөлд зөв чиглэлд оруулахад хэлэлцүүлэг хөтлөгч буюу чиглүүлэгчийн үүрэг асар өндөр. Хэлэлцүүлгийн явцад чиглүүлэгч, оролцогчдын тухайд хоёр урсгалт, тэгш оролцоог хангасан, өөрөөр хэлбэл чиглүүлэгч мэдээлэл өгч, чиглүүлэх асуулт тавьсан, оролцогчид хариулт өгч, санаа бодлоо илэрхийлсэн харилцааг бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай.

Хэлэлцүүлгийн дараа: Иргэдийн санал шийдвэрт хэрхэн туссан талаарх мэдээллийг олон нийтэд хүргэх явдал хамгийн чухал. Өөрөөр хэлбэл оролцооны чухал зарчмын нэг бол эргэх холбоог хөгжүүлэх нь хэлэлцүүлгийн үр дүн, оролцооны тогтвортой байдалд ихээхэн нөлөөтэй юм. Хэлэлцүүлгийн дараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэнээр иргэдэд тэдний санал бодол бодлого, шийдвэрт хэрхэн туссаныг

мэдээлэх, уг үйл ажиллагаанд иргэдийн оролцоо ямар чухал болохыг ойлгуулахаас гадна дараагийн үйл ажиллагаанд оролцох сэдэл хөшүүрэг болж өгдөг.

Зөвлөлдөх оролцооны үед иргэд, сонирхогч талуудаас ирүүлсэн саналыг бодлого, шийдвэрт хэрхэн авч үзсэн талаар эргэн тайлагнах, хариуцлага хүлээх асуудал чухал байдаг. Жишээ нь: АНУ-д иргэдээс ирүүлсэн саналууд нь албан ёсны бүртгэлд орох бөгөөд шийдвэр гаргагчид тодорхой үндэслэлгүйгээр саналыг хүлээн авахаас татгалзсан нөхцөлд шүүхэд дуудагдах эрсдэлтэй байдаг нь хариуцлагын сайн механизм болжээ.

Иргэдийн шууд оролцоо ба хяналт

Мэдээлэх, зөвлөлдөх хэлбэрийн оролцоотой харьцуулахад иргэдийн шууд оролцоо буюу хамтран бүтээх үйл ажиллагаа хязгаарлагдмал байна. Орон нутгийн хөгжлийн тулгамдсан асуудлаа тодорхойлохоос эхлээд иргэдийн оролцоотой төлөвлөгөө боловсруулах, төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх, иргэдийн төлөөллийг ажлын хэсэгт оруулах зэргээр иргэд шууд оролцож байна.

Тулгамдаж буй асуудлаа өөрсдөө тодорхойлох, түүнийг шийдвэрлэх зорилго, зорилтоо хамтран томъёолох, түүний мөрөөр шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлж, үр дүнгээ өөрсдөө үнэлдэг *Хөдөөгийн шууд үр дүн-Rapid rural appraisal* арга нь (R.Chambers, 1995) бодит оролцооны голлон хэрэглэгддэг аргын нэгд багтдаг.

Зураг 4. Иргэдийн шууд оролцоо ба хяналт



Эх сурвалж: ЗГХЭГ, НҮБХХ. 2011.

Үүнээс, иргэд өөрсдөдөө хамаатай тулгамдаж буй асуудлаа тодорхойлох, бодлого боловсруулахад оролцох; өөрсдийнх нь амьдралд нөлөөлж байгаа асуудлаар шийдвэр

гаргах, тодорхой үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хувь нэмрээ оруулах нь иргэдийн бодит оролцоо, хяналтыг тодорхойлж байна.

Хөдөөгийн шууд үр дүн гэсэн аргачлал төсөл, хөтөлбөрүүдэд нэвтэрснээр *Хөдөөгийнхний оролцооны үр дүн-Participatory rural appraisal; Оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ-Participatory monitoring and evaluation; Оролцоонд тулгуурласан сургалт, үйл ажиллагаа- Participatory learning and action* зэрэг нэршлээр өөр өөрийн өвөрмөц онцлогийг тусган хөгжиж иржээ. Эдгээр нь аливаа бодлого шийдвэр, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулах төдий ойлголт биш, иргэд санал бодлоо чөлөөтэй илэрхийлж, хамтдаа шийдвэр гаргах, хамтран төлөвлөлт хийх, төлөвлөсөн үйл ажиллагааг хамтарч хэрэгжүүлэх, хэрэгжүүлсэн үйл ажиллагаагаа хамтарч үнэлэх, хамтарч хариуцлага хүлээх бүхий л үйл явцуудыг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Иргэдийн оролцоот хяналтын хүрээнд нийгмийн аудит, нийгмийн эгэх хариуцлага, хэрэглэгчийн үнэлгээний зарт, хэрэглэгчийн онооны карт, зэрэг арга, аргачлалууд нэвтэрч байна.

Иргэдийн оролцооны CLEAR загвар

Судлаач Ловидас нар 23 мужид туршигдсан загварт тулгуурлан иргэдийн оролцоог үр дүнтэй болгоход анхаарах хүчин зүйлийг багцлан боловсруулсан CLEAR загварыг боловсруулжээ (Тони Бовеирд, Элке Лөйффлер, 2014).

- **Can do-** Хийх чадвартай байх/хийхийн тулд мэдлэг, нөөцтэй байх
- **Like to-** Хүсэл сонирхолтой байх/нэгдэн нийлэх хүсэлтэй байх
- **Enable to-** Боломжтой байх/оролцох бололцоогоор хангагдсан байх
- **Asked to-** Сураглагддаг байх/Байгууллага, сайн дурынхны ажилд дайчлагддаг байх
- **Responded to-** Хариу авдаг байх/Санал бодол тусгагдсан эсэхийг хардаг байх зэрэг болно.

Эцэст нь тэмдэглэхэд, аливаа хэлэлцүүлэг, хурлын нэрийг уламжлалт байдлаар нэрлэхээс татгалзаж, аль болох анхаарах татсан байдлаар оноох нь оролцогчдын анхаарлыг татах, оролцох сонирхлыг өдөөхөд ач холбогдолтой болж байна. Жишээ нь: Brown bag meeting, Мөлхөө ярилцлага, Гудамжны хурал гэх мэт нэршлүүд байж болох юм.

Иргэдийн оролцоог хангасан үйл ажиллагааг сугалаа, хөгжилтэй тэмцээн, асуулт, хариултын нэвтрүүлэг зэрэг албан бус арга хэмжээтэй хослуулан зохион байгуулах нь оролцоог идэвхижүүлэх бас нэг арга болно. Мөн иргэдийн клуб, сонирхлын бүлэг, идэвхтэн, сайн дурын гишүүдийн оролцоо, дэмжлэг иргэдийн оролцоот үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулахад ихээхэн ач холбогдолтой.



Дасгал 2. Бүлгийн ажил: Иргэдийн оролцоог идэвхижүүлэх боломж, арга зам

Үргэлжлэх хугацаа: 40 минут

Аргачлал: Багш оролцогчдыг ойролцоо тооны гишүүнтэй 3 бүлэгт хувааж,

1-р бүлэг: Зөвлөлдөх оролцоо

2-р бүлэг: Шууд оролцоо

3-р бүлэг: Хянах оролцоо гэсэн сэдвийг хуваарилж өгнө.

Оролцогчид оролцооны талаарх онол, арга зүйн мэдээлэл, оролцоог хангаж ажилласан туршлага дээрээ үндэслэн иргэдийн оролцоог идэвхижүүлэх боломж, арга замыг тодорхойлох чиглэлээр дараах даалгаврыг бүлгээрээ хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Тухайн оролцооны түвшинд тодорхой нэг аргыг ашиглан иргэдийн оролцоог хангахад тулгамдаж буй асуудал, тохиолдсон бэрхшээл зэргийг асуудлын мод, загасны нуруу зэрэг аргаар тодорхойлно.
2. Тодорхойлсон асуудлуудаас аль нэгийг нь шийдвэрлэх аль болох бодитой санал, арга замын хувилбар боловсруулах, эсвэл өмнө нь уг асуудлыг шийдвэрлэж байсан туршлагаа танилцуулна.

Бүлгийн ажлын үр дүнг нэг гишүүн танилцуулах ба танилцуулгын хүрээнд асуулт тавих, хариулах зэргээр санал солилцох, улмаар иргэдийн оролцоог хангах үйл ажиллагааг зохион байгуулах арга барилыг дээшлүүлэх, өөр хоорондоо туршлага солилцох боломж бүрдүүлж ажиллана.



Багшид өгөх зөвлөмж

Багш бүлгүүдээс оролцоонд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл буюу бэрхшээлийг бүрэн тодорхойлсон эсэхийг хянаж, байж болох хүчин зүйлүүдийг хамруулсан эсэхийг анхаарна. Мөн хамгийн гол нөлөөтэй бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд санал болгож буй хувилбарыг SMART шалгуур (Тодорхой, Хэмжигдэхүйц, Үйл ажиллагаанд чиглэсэн, Бодитой, Цаг хугацааны хувьд боломжтой)- аар үнэлж, ярилцана.

1.4. Багшийн дүгнэлт

Оролцооны зарчим нь эрхэд суурилсан; асуудал, үйл ажиллагаанд холбоотой бүхий л талуудыг хамардаг; тэдний үзэл бодол, дуу хоолой, идэвх санаачлагыг бодлого шийдвэртээ тусгадаг; хамтран бүтээх үйл ажиллагааг хөхиүлэн дэмждэг утгаараа шинэ тутам хөгжиж буй үзэл баримтлал, үйлдлэг болж байна. Тэр дундаа иргэд, олон нийтийн оролцоо нь ардчилал, сайн засаглалыг хөгжүүлэх, төлөвшүүлэх суурь хүчин зүйл юм.

Улс орнуудад иргэдийн оролцоо нь мэдээлэх, зөвлөлдөх, шууд оролцох болон хяналт тавих гэсэн нийтлэг аргаар хэрэгжиж байна. Эдгээр нийтлэг арга доторх олон төрлийн хэлбэрээс зорилго, хөрөнгө нөөц, иргэдийн онцлог зэргийг харгалзан үзэж, тохирох хэлбэрийг сонгох шаардлага бий. Сүүлийн жилүүдэд төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагаас иргэдэд мэдээлэл түгээх оролцоо, нөлөөллийн идэвхгүй хэлбэрээс төр-иргэн нээлттэй санал солилцох, зөвлөлдөх, төлөвлөх, төлөвлөсөн үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, үнэлэх чиглэлийн идэвхтэй оролцоог хангах чиглэлд ихээхэн санал, санаачлага гарч байна.



Ашигласан болон уншиж судлах эх сурвалж

- Амаржаргал, Т., Оюун Ч., нар. (2012), *Олон нийтийг идэвхжүүлэх арга зүй*. Төрийн болон төрийн бус байгууллагын олон нийттэй харилцах ажилтнуудад зориулсан гарын авлага, Улаанбаатар
- Болд-Эрдэнэ, Б., Өнөрбаяр Г., (2011), *Төрийн байгууллагын мэдээлэл харилцаа* гарын авлага, Улаанбаатар
- Ганцэцэг С., (2017), Олон нийтийн оролцоог хангах эрх зүйн зохицуулалт, *Хороодын зохион байгуулагчдад зориулсан модуль сургалтын гарын авлага*, Нийслэлийн Засаг даргын тамгын газар, Удирдлагын академи, Азийн сан, Швейцарийн хөгжлийн агентлаг, Улаанбаатар
- Дэннис Рондинэли. (2008), Ардчилсан засаглалын нөхцөлд төрийн захиргааны албадын чиг үүрэг өөрчлөгдөх нь: Иргэддээ үйлчилдэг Засгийн газар , *Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: Иргэддээ үйлчилдэг Засгийн газар*, НҮБХХ, Улаанбаатар
- ЗГХЭГ, НҮБХХ. (2011), *Орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог хангах нь*. Улаанбаатар
- Жеймс С. Фишкин (Орч. Г. Занданшатар). (2009), *Хүмүүс үзэл бодлоо илэрхийлэхүй*. Зөвлөлдөх ардчилал ба Олон нийтийн зөвлөлгөөн, Улаанбаатар
- Мягмарцоож Н, (2010), *Төрийн бодлогын үйл явц дахь иргэдийн оролцоо*. Улаанбаатар
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар. (2013), *Шууд ардчилал–Иргэдийн оролцоо* Бодлогын баримт бичгийн эмхэтгэл, Улаанбаатар
- Нарантулга Б., (2009), *Оролцооны хяналт-шинжилгээний үнэлгээний гарын авлага*, БОАЖЯ, Канадын олон улсын хөгжлийн судалгааны төв, Улаанбаатар
- Нармандах С., (2014), Иргэний ардчилсан нийгмийн нутгийн өөрийн удирдлага өгүүлэл, *Өгүүллийн эмхэтгэл*, Удирдлагын академи, Улаанбаатар
- Тони Бовеирд, Элке Лейффлер (Орч. С.Зульфикар, Я.Очирсүх, В.Өлзийбаяр). (2014), *Улсын салбарын менежмент, засаглал*, Удирдлагын академи

- Чанцалдулам Ж., Оюунтуяа С, (2011), *Орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо гарын авлага*, Нийгмийн дэвшил эмэгтэйчүүд хөдөлгөөн, Улаанбаатар
- Энхцэцэг Д., (2016), *Нийслэлийн хариуцлагатай иргэн*, НЗДТГ, ННФ, Швейцарийн хөгжлийн агентлаг, Азийн сан, Улаанбаатар
- Chambers. R., (1995), *Revolutions in development inquiry*, London, UK
- Giddens. A., (1979). *Central problems in social theory: Action, structure and contradiction in social analysis*, California, USA
- International Development Research Center. (2005), *Participatory Monitoring and Evaluation Handbook for development researchers*, Canada
- Lofquest A.W., (1993), *The prevention of workbook. A leadership development program*, Arizona, USA
- OECD. (2001), *Citizens as partners: Information, consultation and public participation in policy making*, France
- Oaklay P., (1991), *The concept of participation in development. Landscape and Urban planning*, USA



НҮБ-ЫН
ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨР



УДИРЛААГЫН
АКАДЕМИ

ИРГЭДИЙН ОРОЛЦООГ ДЭМЖИХ НЬ

Агуулга



Иргэдийн оролцооны талаарх
ойлголт



Иргэдийн оролцоог дэмжих
арга



Иргэдийн оролцоот үйл
ажиллагааг зохион байгуулалт




I. Иргэдийн оролцооны талаарх ойлголт

Дасгал 1. Оролцооны талаарх ойлголтоо
нэгтгэх нь (15 минут)

Оролцоо ба сайн засаглал

1960-аад он: Барууны улс орнууд
1980-аад он: Хоёр үндсэн хандлага

- Хөгжил дэх оролцоо
- Оролцоонд тулгуурласан хөгжил



Нутгийн өөрөө удирдах
байгууллага/
Иргэдийн төлөөлөгчдийн хурал

Иргэдийн оролцооны талаарх ойлголт

Оролцоо?

Хэрэгцээ, сонголт

Хандлага, зан үйл

Дэмжих, эс дэмжих үйл ажиллагаа

Үр ашигтай нөлөөлөл

Манлайлал

Иргэдийн оролцоо- Төрийн бодлого шийдвэр (ИТХ-ын тогтоол, шийдвэр, Орон нутгийн дэд хөтөлбөр), үйл ажиллагааг дэмжих болон тэдгээрт нөлөөлөхийн тулд иргэдийн зүгээс хийж байгаа аливаа үйлдэл;

Иргэдийн улс төрийн оролцоо- Нийгмийн улс төрийн амьдрал, үйл явц болон төрийн, нутгийн удирдлагын байгууллага, тэдгээрийн бодлого, шийдвэрийг дэмжих, эс дэмжих байдлаар илрэн гарч буй нөлөөлөл;

Иргэд оролцох хэрэгцээ



Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Оновчтой сонголт
- ✓ Нээлттэй харилцаа
- ✓ Хариуцлага, тунгалаг байдал
- ✓ Төлөөллийн зарчим, олон нийтийн итгэл



Иргэд:

- ✓ Мэдээлэл, мэдлэг
- ✓ Туршлага, чадавхи
- ✓ Иргэний эрх, үүрэг
- ✓ Хөгжилд оруулах хувь нэмэр

Оролцооны зарчим

- Бодитой мэдээлэл, нэгдсэн ойлголт
- Олон ургалч үзэл, зөвшилцөл
- Мэдлэг, чадвар, туршлага ба оновчтой шийдвэр
- Хамтран бүтээх, зорилгодоо хүрэх боломж
- Хамтын ажиллагаа, харилцан суралцах, чадавхижих нөхцөл
- Үнэлгээ, эргэх холбоо ба үр дүн, тогтвортой байдал



БҮТЭЭЛЧ ОРОЛЦОО


- Итгэлцэл
- Нотолгоонд суурилсан
- Үр дүн, шийдэлд чиглэсэн
- Тогтвортой



II. Иргэдийн оролцоог дэмжих арга

Иргэдийн оролцооны шатлал

1. Мэдээлэлгүй байх
2. Мэдээлэл авах
3. Сонирхол төрөх
4. Мэдээлэх
5. Зөвлөлдөх
6. Туршиж үзэх
7. Даган дуурайх
8. Хэрэгжүүлэх



Ш.Арноштейн, Оролцооны шатлал

- Идэвхтэй & Идэвхгүй
- Сайн дурын & Зохион байгуулалттай
- Тогтмол & Түр зуурын

Оролцоо жинхэнэ утгаараа төлөвшихөд цаг хугацаа, хүчин чармайлт, арга барил шаардана.

Оролцооны үндсэн арга


- **Мэдээлэл** (Мэдээлэл бол иргэдийн оролцооны үндэс бөгөөд мэдээлэл хүлээн авах, ашиглах, түгээх бүлэг үйл ажиллагаа)
- **Зөвлөлдөөн** (бодлого шийдвэр гаргах, үйл ажиллагаа хэрэгжүүлэхдээ иргэдтэй санал солилцож, тэдний санаа бодлыг тусгах)
- **Шууд/идэвхтэй оролцоо** (Бодлого шийдвэр, үйл ажиллагаанд иргэд шууд биечлэн оролцох үйл ажиллагаа)
- **Хяналт** (Аливаа бодлого шийдвэр, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг хянах, сайжруулах ажиллагаа)

Оролцооны эрх зүйн зохицуулалт

	Агуулга	Тоо
1	Ил тод байдлыг хангах; хуулиар нууцад хамааруулснаас бусад мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байлгах; мэдээлэл авах хүсэлтийг шуурхай шийдвэрлэх; шийдвэрлээгүй нөхцөлд гомдол гаргах; сургалт сурталчилгаа, таниулга хийх	68
2	сонгуульд оролцох; санал асуулга явуулах; бодлого, хууль тогтоомжид болон шийдвэр гаргахын өмнө иргэдээс санал авч, тусгах; иргэдээс өргөдөл гаргах; олон талт бүтцийн нэгж /хороо, зөвлөл ажиллуулах	25
3	нийтийн сонсгол; цуглаан; мэргэжилтнүүдийг оролцуулсан ажлын хэсэг; ИНБ, ТББ-уудтай хамтран ажиллах; тэдгээрээр тодорхой ажил, үүрэг гүйцэтгүүлэх; олон талт бүтцийн нэгжид төлөөллөө оролцуулах (үнэлгээний хороо, стандартчиллын хороо)	44
4	хуулийн хэрэгжилтэд хамтран болон дангаар хяналт тавих; хуулийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх; зөрчил гарсан нөхцөлд өргөдөл гомдол гаргах; нийтийн эрх ашгийг төлөөлөн нэхэмжлэх	24

МУ-д иргэд, олон нийтийн оролцоог зохицуулж буй 105 хууль байна.

Нөлөөллийн түвшин



**III. Иргэдийн оролцоот
үйл ажиллагааг зохион
байгуулах нь**

Оролцооны стандарт

- Амьдрал, үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гарахад олон нийтийн дуу хоолойг сонссон байх
- Оролцогчдыг утга учиртай, зохистой арга замаар оролцоход шаардагдах мэдээллээр хангах
- Асуудлыг тодорхойлоход зөвшилцөл, ойлголцол, хамтын идэвхитэй үйл ажиллагаанд үндэслэх
- Үйл явц нь янз бүрийн сонирхлуудыг холбож, оролцогчийн санал санаачилгыг дэмжиж, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн байх
- Шийдвэр, үйл ажиллагаанд хамааралтай оролцогчдыг үйл явцад татан оролцуулж, тэдний санал санаачилгыг шийдвэрт харгалзах
- Оролцогч талыг оролцооны чиглэл, зохион тодорхойлоход оролцогчдыг татан оролцуулах
- Оролцоо шийдвэрт хэрхэн нөлөөлсөнийг оролцогчдод тухай бүр тодорхой мэдээлэх

Мэдээлэл түгээх үйл ажиллагаа

Зорилго

- Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааныхаа талаар танилцуулах
- Үйл ажиллагаандаа зориулан дэмжлэг, санхүүжилт цуглуулах
- Олон нийтийн анхаарлыг татах, тэднийг үйл ажиллагаандаа татан оролцуулах
- Бодлого, хууль тогтоомжид эерэг нөлөө үзүүлэх
- Иргэд, олон нийтийн хандлагыг өөрчлөх


- ✓ **МЭДЭЭЛЭЛ ТҮГЭЭХ**
- ✓ **ИДЭВХТЭЙ АРГА!!!**
- ✓ **ТОХИРОМЖТОЙ ХЭРЭГСЭЛ!!!**

Хэлбэр

- Биечилсэн болон видео танилцуулга хийх, уулзалт зохион байгуулах
- Сонин, сэтгүүл, зурагт хуудас, товхимол, гарын авлага зэрэг хэвлэмэл материал боловсруулж, тараах
- Мэдээллийг өрх, иргэн бүрт биечлэн хүргэх, цахим болон цаасан захидал бичих
- Мэдээллийн төв, мэдээллийн болон зарлалын самбар, мэдээлэл өгөх утас ажиллуулах
- Бага хурал, үзэсгэлэн болон хэвлэлийн бага хурал зохион байгуулах гм.

Зөвлөлдөх үйл ажиллагаа


- Иргэний зөвлөл
- Иргэний танхим
- Нээлттэй хэлэлцүүлэг
- Бүс нутгийн болон тодорхой асуудалд чиглэсэн форум
- Санал асуулга
- Фокус бүлгийн ярилцлага
- Иргэдийг сонсох өдөрлөг
- Иргэдийн санал, зөвлөмж авах хайрцаг





Хэлэлцүүлгийн менежментийн 4 сануулга (Brian Tracy)

- Зорилго, хэлэлцүүлгийн тов, байршил, хэлэлцэх асуудлыг тодорхой болгох
- Хэлэлцүүлгийн явцад иргэдэд чөлөөтэй оролцож, санал бодлоо илэрхийлэх боломж бүрдүүлэх
- Хэлэлцүүлгийг сайтар удирдан чиглүүлэх, хэлэлцсэн асуудлын талаар дүгнэлт хийх
- Хэлэлцүүлгийн талаар тайлан, тэмдэглэл хөтөлж гарсан шийдвэрийн хамт иргэдэд түгээх

Нэг чиглэлтэй буюу зөвхөн чиглүүлэгч мэдээлж, оролцогчдын санаа бодлыг сонсоогүй харилцаа



Хоёр чиглэлтэй, тэгш оролцоог хангасан харилцаа



Хоёр чиглэлтэй боловч оролцоог хангаагүй харилцаа

Шууд оролцоо ба хяналт



- Хөдөөгийн шууд үр дүн/Rapid rural appraisal
- Нийгмийн эгэх хариуцлага
- Нийгмийн аудит
- Оролцооны хяналт-шинжилгээ, үнэлгээ гм.

Иргэдийн оролцооны **CLEAR** загвар

- **Can do**- Хийх чадвартай байх/хийхийн тулд мэдлэг, нөөцтэй байх
- **Like to**- Хүсэл сонирхолтой байх/нэгдэн нийлэх хүсэлтэй байх
- **Enable to**-Боломжтой байх/оролцох бололцоогоор хангагдсан байх
- **Asked to**-Сураглагддаг байх/Байгууллага, сайн дурынхны ажилд дайчлагддаг байх
- **Responded to**-Хариу авдаг байх/Санал бодол тусгагдсан эсэхийг хардаг байх

Дасгал 2. Иргэдийн оролцоог
идэвхижүүлэх боломж, арга зам
(25 минут)

Анхаарал хандуулсанд баярлалаа.